



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/68

Баянхутаг сум

**“СУМЫГ НҮҮН ШИЛЖҮҮЛЭХ”  
СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ  
ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын 2 дугаар хавсралтын 2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд иргэдийг нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсугай.

Газар хөдлөлтийн гамшгийн улмаас нэрвэгдэгсдийг сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд заасан байршилд нүүлгэн шилжүүлэх түр байр, хоол хүнс, нийгмийн үйлчилгээгээр хангах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг сумын Онцгой комиссын шуурхай штабын дарга (Г.Болд)-д даалгасугай.

Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Наранбадрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501068

Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 4/хдугаар захирамжийн 1. дүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН НҮҮН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

НҮҮН ШИЛЖҮҮЛЭЛТ: Болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтонд байгаа хүн ам, мал амьтан, эд хөрөнгийг зохион байгуулалттайгаар аюулгүй орчинд шилжүүлэн байршуулах арга хэмжээг хэлнэ.

| №                                          | Гүйцэтгэх ажлууд                                                                                                                              | Хугацаа    | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан |                      | Хамтран хэрэгжүүлэгч              | Хяналт тавих албан тушаалтан |
|--------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------------------------|----------------------|-----------------------------------|------------------------------|
|                                            |                                                                                                                                               |            | Байгууллага                                       | Албан тушаалтан      |                                   |                              |
| Нэг. Нүүн шилжүүлэх ажиллагааны удирдлага: |                                                                                                                                               |            |                                                   |                      |                                   |                              |
| 1                                          | Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө гаргах                                                                                            | 2025.06.12 | ЗДТГ                                              | Сумын Засаг дарга    | Орон нутгийн бүх байгууллага      | Засаг даргын орлогч          |
| 2                                          | Сумын Онцгой комисс, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг зарлан мэдээллийн дохиогоор цуглуулах | 2025.06.12 | ЗДТГ                                              | Шуурхай штабын дарга | Гамшгаас хамгаалах томилгоот нэгж | Сумын Онцгой комисс          |
| 3                                          | Удирдах гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг танилцуулах                                                                  | 2025.06.12 | ЗДТГ                                              | Засаг дарга          | Орон нутгийн бүх байгууллага      | Засаг даргын орлогч          |



|   |                                                                                                                                                                                                                                                                                                            |                       |                                 |                      |                                                               |                                   |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|---------------------------------|----------------------|---------------------------------------------------------------|-----------------------------------|
| 4 | Гамшиг үүссэн буюу болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагаа явуулах зорилгоор нүүн шилжүүлэлт явуулах тухай шийдвэр гаргах                                                                                                                                                                  | 2025.06.24            | ЗДТГ                            | Засаг дарга          | Сумын бүх байгууллага, ард иргэд                              | Сумын Онцгой комисс, шуурхай штаб |
| 5 | Ерөнхий зориулалтын болон бусад томилгоот бүрэлдэхүүнийг зарлан мэдээллийн дохиогоор цуглуулж, бэлэн байдлыг шалган үүрэг зааварчлага өгч, ажилд томилон үүрэг гүйцэтгүүлэх                                                                                                                                | 2025.06.12-2025.06.20 | Сумын засаг даргын орлогч дарга | Засаг даргын орлогч  | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, нүүлгэн шилжүүлэх бүлэг | Сумын онцгой комисс               |
| 6 | Удирдлагын байранд Засаг даргын шийдвэр, ажлын зурагт гамшгийн болон нүүн шилжүүлэлтийн цагийн байдлыг оруулах                                                                                                                                                                                             | 2025.06.13            | Шуурхай штаб                    | Шуурхай штабын дарга | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                          | Сумын онцгой комисс               |
| 7 | Гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүн шилжүүлэлт явуулах шийдвэр гарсан тухай нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зарлан мэдээллийн бүх хэрэгсэлээр зарлах                                                                                                                                               | 2025.06.12-2025.06.22 | Шуурхай штаб                    | Шуурхай штабын дарга | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                          | Сумын онцгой комисс               |
| 8 | Засаг даргын захирамжаар нүүн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах:<br>-Тээврийн бүлэг<br>-Эмнэлэг эруул ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг<br>-Хэв журам сахиулах, зохицуулах бүлэг<br>-Инженерийн бүлэг<br>-Нөөцийн материал, орон сууцны хангалтын бүлэг<br>-Холбоо мэдээлэл, лавлагааны бүлэг | 2025.06.20-2025.06.26 | ЗДТГ                            | Засаг дарга          | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                          | Сумын онцгой комисс               |

|                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                       |                                   |                             |                                                                                                                         |                     |
|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------------------|-----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
|                                        | -Хоол хүнсний хангалтын бүлэг -Шатахуун нефтийн бүтээгдэхүүний хангалтын бүлэг<br>-Банк, санхүү, нийгмийн хамгааллын бүлэг<br>-хүн ам, эд хөрөнгө, мал, амьтаныг тоолох иргэний бүртгэл, мэдээллийн бүлгийг тус бүрийн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй томилж үүрэг, чиглэлээр ханган цугларах цэгт нүүн шилжүүлэх ажиглагааг эхлүүлэх |                       |                                   |                             |                                                                                                                         |                     |
| 9                                      | Шийдвэрт заасан аюулгүйн бус буюу цугларах цэгт иргэдийг нүүн шилжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах                                                                                                                                                                                                                   | 2025.06.24-2025.06.26 | Шуурхай штаб                      | Засаг даргын орлогч         | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                                                                                    | ЗДТГ-ын дарга       |
| 10                                     | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулахтай холбогдуулан иргэдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд гарах зардлын тооцоог гаргах                                                                                                                                                                                   | 2025.06.16-2025.06.28 | Сумын Онцгой комисс, Шуурхай штаб | Сумын Онцгой комиссын дарга | Аймгийн ЗДТГ, Аймгийн ОК, Сумын ИТХ, ЗДТГ, ААН, Төрийн байгууллагууд, МУЗНийгэмлэг, ОУБайгууллага, Иргэд хуулийн этгээд | Сумын Онцгой комисс |
| Хоёр. Нүүн шилжүүлэлт зохион байгуулах |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                       |                                   |                             |                                                                                                                         |                     |
| 11                                     | Нүүн шилжүүлэлтэнд хамрагдах хүн амын тоо, бүртгэлийг явуулж, орон байр, хоол хүнсээр хангах, үнэт зүйлсийг тээвэрлэлтэнд бэлтгэх, байршуулах                                                                                                                                                                                   | 2025.06.24-2025.06.26 | Шуурхай штаб                      | Засаг даргын орлогч         | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                                                                                    | ЗДТГ-ын дарга       |



|                                          |                                                                                                                                                                                                          |                       |                                                 |                     |                                                           |
|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-------------------------------------------------|---------------------|-----------------------------------------------------------|
|                                          | аюулгүй бүс рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулах                                                                                                                                                         |                       |                                                 |                     |                                                           |
| 12                                       | Нүүн зохион байгуулж байгаа Засаг даргын Тамгын газар, бүлгүүдийн удирдлага, цугларах цэгийг холбооны хэрэгслээр хангах                                                                                  | 2025.06.24-2025.06.26 | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги            | Засаг даргын орлогч | Багийн Засаг дарга нар<br><br>ЗДТГ-ын дарга               |
| 13                                       | Мэдээ, мэдээллээр хангах                                                                                                                                                                                 | 2025.06.24-2025.06.26 | Шуурхай штаб                                    | Засаг даргын орлогч | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги<br><br>ЗДТГ-ын дарга |
| Гурав. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд |                                                                                                                                                                                                          |                       |                                                 |                     |                                                           |
| 14                                       | Гамшгийн нөхцөл байдал, сумын Засаг даргын шийдвэртэй уялдуулан байгууллагын шийдвэр гаргаж мөрдөх                                                                                                       | 2025.06.24-2025.06.26 | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар | Засаг даргын орлогч | ЗДТГ<br><br>ЗДТГ-ын дарга                                 |
| 15                                       | Томилгоот болон нийт бүрэлдэхүүнийг зарлан мэдээллийн дохиогоор цуглуулж, төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгүүлэх                                                                                         | 2025.06.24-2025.06.26 | Шуурхай штаб                                    | Засаг даргын орлогч | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги<br><br>ЗДТГ-ын дарга |
| 16                                       | Байгууллагаас дайчлагдсан хүч хэрэгсэл, нүүн шилжигсдийн мэдээ гаргах, нүүлгэн шилжүүлэлтийн явц байдал, гаргасан зардал, бусад тайлан мэдээг тогтоосон хугацаанд Засаг даргын Тамгын газарт танилцуулах | 2025.06.24-2025.06.26 | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар | Засаг даргын орлогч | ЗДТГ<br><br>ЗДТГ-ын дарга                                 |
| 17                                       | Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх                                                                                                                                   | 2025.06.24-2025.06.26 | Шуурхай штаб                                    | ЗДТГ-ын дарга       | ЗДТГ<br><br>Засаг даргын орлогч                           |
| 18                                       | ИРГЭД: Шаардлагатай бичиг баримт, хүнс, хувцас хэрэгслийг                                                                                                                                                | 2025.06.24-2025.06.26 | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар | Засаг даргын орлогч | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги<br><br>ЗДТГ-ын дарга |

|    |                                                                                                                                                                                                 |                       |                                                        |                     |                                                 |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|--------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------|
|    | Бэлтгэж, цугларах газарт тогтоосон хугацаанд очих                                                                                                                                               |                       |                                                        |                     |                                                 |
| 19 | Булгуудийн удирдлагын зүгээс тавьсан шаардлага, тогтоосон дэглэм, зөвлөмжийг хэрэгжүүлэх                                                                                                        | 2025.06.24-2025.06.26 | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги                   | ЗДТГ-ын дарга       | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар |
| 20 | Нүүн шилжүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, бусдад дэмжлэг үзүүлэх                                                                                                                        | 2025.06.24-2025.06.26 | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар, иргэд | ЗДТГ-ын дарга       | МУЗН, ОУБайгууллага                             |
| 21 | Сургуулийн өмнөх насны хуухдийн лавлагаа /овог нэр, төрсөн он, сар, өдөр, үндсэн хаяг, очих газрын нэр, регистрийн дугаар, утасны дугаар/-ыг даавуун дээр бичиж хувицасны дотор талд оёсон байх | 2025.06.24-2025.06.26 | АНН, төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч нар, иргэд | Засаг даргын орлогч | Ерөнхий зориулалттай мэргэжлийн анги            |
|    |                                                                                                                                                                                                 |                       |                                                        |                     | Засаг даргын орлогч                             |